



Хураангуй зөвлөмж

- Үнэлгээний дүнгээс харвал газар тариалангийн салбарын холбогдох бодлого, хөтөлбөрүүдэд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудал тусгайлан зааж, нарийвчлан тусгасан заалт хомс, энэ асуудал орхигдсон байна.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудалтай ямар нэгэн байдлаар дам холбогдох, газар тариалангийн салбарын технологи, арга хэмжээг сайжруулах, менежментийг боловсронгуй болгох чиглэлийн ерөнхий асуудлууд нэлээд туссан байна.
- “Газар тариалангийн салбарын уур амьсгалын өөрчлөлтөд ухаалгаар зохицон хөгжих” Үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх. Э
- Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хариуцсан байгууллагууд болон газар тариалангийн салбарын байгууллага, их сургууль, хүрээлэнгийн ажлын уялдаа холбоог хангах, сайжруулах, хамтарсан төсөл хөтөлбөр санаачлан хэрэгжүүлэх,
- Газар тариалангийн салбарын ажилтнууд, тариаланчид, фермерүүдэд зориулсан сургалты уур амьсгалын өөрчлөлтийн тухай мэдлэг, мэдээллийг сайжруулах, сургалт хийх,
- Газар тариалангийн салбарын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлаар төслийн санал боловсруулах, Уур амьсгалын ногоон санд төслийн саналаа хүргүүлэх

Газар тариалангийн салбарын бодлогын баримт бичигт уур амьсгалын өөрчлөлтийн дасан зохицолын асуудал хэрхэн туссан байдлын үнэлгээ

Зорилго

Монгол орны нөхцөлд дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр дулааны улирлын хур тунадас багасах, хуурайших, байгалийн экосистем, хөрсний чанар доройтож байгалийн бүс бүслүүр шилжин, говь цөлийн хуурай бүс хойд зүг рүү шилжих, хэрэгжүүлэх зорилт зайлшгүй тулгарч байна.

Түүнчлэн газар тариалангийн салбарын бодлого, эрх зүйн баримт усны нөөц хомсдох, хөрсний чийгийн горим алдагдаж, гүний усны түвшин доошлох, байгалийн гамшигт үзэгдлийн давтамж, эрчим нэмэгдэх зэрэг нь газар тариалангийн салбарт маш таагүй нөлөө, үр дагавар учруулж болзошгүй байна. Иймд газар тариалангийн салбарыг цаашид үр ашигтай, тогтвортой хөгжүүлэх, улс орны хүнсний аюулгүй байдлыг баталгаатай хангахын тулд Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлийг ухаалгаар тооцсон газар тариалангийн хөгжлийн загвар, хувилбарыг бий болгож бичигт уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах, засан зохицох арга хэмжээг тусгаж хэрэгжүүлэх явдал нэн чухал.

Энэхүү үнэлгээний хүрээнд газар тариалангийн салбарын бодлого, эрх зүйн баримт бичигт уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, дасан зохицох асуудал хэрхэн туссан байдал болон энэ зорилтыг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтын орчин хэрхэн бүрдсэн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх явдал байв.



Гол үр дүн, дүгнэлт:

- Үнэлгээний дүнгээс харвал газар тариалангийн салбарын холбогдох бодлого, хөтөлбөрүүдэд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудал тусгайлан зааж, нарийвчлан тусгасан заалт хомс, энэ асуудал орхигдсон гэж үзэж болохоор байна.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудалтай ямар нэгэн байдлаар дам холбогдох, газар тариалангийн салбарын технологи, арга хэмжээг сайжруулах, менежментийг боловсронгуй болгох чиглэлийн ерөнхий асуудлууд нэлээд туссан байна.
- Газар тариалангийн үйлдэрлэлийг цаашид тогтвортой хөгжүүлэхтэй холбоотой тариалалтын технологийг боловсронгуй болгох, халуун хуурай нөхцөлд тохирсон таримлын сорт гаргах, шинэ таримал тариалах, газар тариалангийн салбарын ус ашиглалт, хөрс хамгаалах зэрэг заалтууд орсон байна. Эдгээр арга хэмжээ нь мөн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох ерөнхий зорилтын хэрэгжилтэд нөлөө үзүүлэх болно.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудалтай холбогдож болох арга хэмжээг хэрэгжүүлэх механизм, хариуцах байгууллага, хөрөнгө санхүүгийн асуудал хангалттай тусгагдаагүй байна.
- Арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн тодорхойгүй байна.
- Газар тариалангийн салбарын төрийн байгууллагууд, Их сургууль, Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд тодорхой хэмжээгээр оршиж, салбарын мэргэжилтэн бэлтгэн, салбарын хэмжээний эрдэм шинжилгээ, судалгааны ажил өргөнөөр хийж байгаа боловч тэдгээрт салбарын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлого боловсруулах, арга хэмжээний хувилбарууд боловсруулж хэрэгжүүлэх явдал хангалтгүй, ажилтнуудын энэ талын мэдлэг, мэдээлэл, чадавхи, боломж сул байна.
- Газар тариалангийн салбарт уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэх сөрөг нөлөөллөл, эрсдэлийг бууруулах болон дасан зохицлын арга хэмжээний тухай цэгцтэй бодлого, стратеги, үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө одоогоор байхгүй байна.

Санал, Зөвлөмж:

- “Газар тариалангийн салбарын уур амьсгалын өөрчлөлтөд ухаалгаар зохицон хөгжих” Үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх. Энэхүү хөтөлбөрт дараах үндсэн асуудлуудыг тусгах. Үүнд:
 - Уур амьсгалын өөрчлөлтийн газар тариалангийн салбар, таримал ургамалд үзүүлэх нөлөөлөл, учрах эрсдэлийн нарийвчилсан судалгаа хийх,
 - Уур амьсгалын өөрчлөлтийн эерэг таатай нөлөөллийг бүрэн ашиглах, сөрөг нөлөөллийг даван туулах боломжийг судлах, дасан зохицлын арга хэмжээний хувилбаруудыг боловсруулах, үр нөлөөг үнэлэх,
 - Газар тариалангийн салбарт Дасан зохицлын арга хэмжээг хэрэгжүүлэх стратеги, арга зам (шаардлагатай техник технологи, санхүүжилтийн механизм, чадавхи боломж бүрдүүлэх г.м)-ыг тодорхойлох,
 - Эдгээр зорилт арга хэмжээг салбарын бодлого, үйл ажиллагаатай хэрхэн уялдуулах,
 - Хөрс, газар тариалангийн салбараас ялгарах хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн зарим арга хэмжээг тусгах.



- Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын одоогийн мөрдөж байгаа бодлого, хөтөлбөрт уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, дасан зохицох асуудал хангалтгүй туссан байгаад анхаарал хандуулж арга хэмжээ авах, шинээр боловсруулах бодлого, стратеги, хөтөлбөрт энэхүү асуудлыг тодорхой тусгах,
- Монгол улсын хөгжлийн асуудлаарх болон уур амьсгалын өөрчлөлтийн талаар баримтлах бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөнд дэвшүүлсэн газар тариалангийн салбартай холбоотой арга хэмжээг салбарын бодлого, стратеги, хөтөлбөртэй уялдуулж, тэдгээрт тусган хэрэгжүүлэх,
- Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хариуцсан байгууллагууд болон газар тариалангийн салбарын байгууллага, их сургууль, хүрээлэнгийн ажлын уялдаа холбоог хангах, сайжруулах, хамтарсан төсөл хөтөлбөр санаачлан хэрэгжүүлэх,
- Газар тариалангийн салбарын байгууллагууд, их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн ажилтнуудын уур амьсгалын өөрчлөлтийн тухай мэдлэг, мэдээллийг сайжруулах, сургалт явуулах, хамтарсан уулзалт, хэлэлцүүлгийг тогтмол хийх, салбарын мэргэжилтнүүдийг уур амьсгалын өөрчлөлтийн холбоотой төсөл хөтөлбөр, арга хэмжээнд идэвхтэй оролцох бололцоогоор хангах,
- Уур амьсгалын өөрчлөлтийн болон газар тариалангийн салбарын мэргэжилтэн, судлаачид хамтран төсөл хөтөлбөр санаачлах, боловсруулах, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, Уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр газар тариалангийн салбарын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлаар төслийн санал, үзэл баримтлал, төслийн бичиг баримт боловсруулах, уг санд төслийн саналаа хүргүүлэх ажлыг эхлүүлэх, энэ талаар НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага болон бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах,
- ХАА, газар тариалангийн салбарын мэргэжилтнүүд, Их сургууль, Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судлаачдыг холбогдох мэдээллээр хангах, тэдэнд зориулсан сургалт, семинар зохион байгуулах,
- Орон нутгийн газар тариалан эрхлэгчид, фермерүүдэд зориулсан сургалтыг аймгуудад болон бүсчилсэн байдлаар хийж, уур амьсгалын өөрчлөлтөд хэрхэн дасан зохицох, хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээний талаар сургалт хийж, мэдээллээр хангах,
- Газар тариалангийн салбар, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, эрсдэл, дасан зохицох талаар ном товхимол, гарын авлага материал боловсруулж, холбогдох талуудад түгээх.

Ашигласан эх мэдээллийн жагсаалт:

1. Монгол улсын Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр 2000, 2011.
2. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Монгол улсын оруулах хувь нэмэр (INDC), 2015:
3. Уур амьсгалын өөрчлөлтийн Технологийн хэрэгцээ, шаардлагын үнэлгээ. Боть 1: Уур амьсгалын өөрчлөлтийн дасан зохицол
4. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Монгол улсын оруулах тодорхойлсон хувь нэмэр (NDC), 2019
5. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030, 2016
6. Монгол улсын “Ногоон хөгжлийн бодлого”, (2014-2030), 2016
7. “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”, 2015



8. Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2016
9. “Атрын III аян” хөтөлбөр
10. “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр
11. “Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөр
12. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, ...
13. “Уур амьсгалд зохицсон ухаалаг хөдөө аж ахуй” –н тухай НҮБ-ын ХХААБ-ын Гарын авлага, зөвлөмж
14. Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, www.irimhe.namem.gov.mn
15. Уур амьсгалын өөрчлөлт, хөгжил академи, www.ccd-academy.com
16. Хөдөө аж ахуйн их сургууль, <http://www.muls.edu.mn>
17. ХААИС-ийн Агроэкологи, Бизнесийн сургууль. <http://www.sab.edu.mn/about-us/overview/>

Тайлбар: Энэхүү бодлогын зөвлөмжид багтсан баримт, дүгнэлтийн үнэн зөв байдлыг зохиогч хариуцна. Уг зөвлөмж нь Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” (MNG 19-01) төслийг санхүүжүүлэгч ХБНГУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.

Зохиогч

Доктор Д. Дагвадорж
Уур амьсгалын өөрчлөлт – Хөгжил
академи